



LEGAL NEWSLETTER

2026.08.24

№69

AKP Law Firm

Бид 2026 оны 08 дугаар сарын 24-ны өдрийг хүртэлх батлагдсан онцлох хууль, тогтоол, шийдвэрүүдийг танилцуулж байна.

I. ХУУЛЬ ТОГТООМЖ:

1.1 Улсын нисэхийн тухай /Шинэчилсэн найруулга/

Тус хууль нь улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагуудын үйл ажиллагааг нэгдсэн бодлого, удирдлагаар хангах, тэдгээрийн чиг үүргийг хуулиар тодорхойлох, улсын нисэхийн багц дүрмээр зохицуулах харилцааг нарийвчлан заах, улсын агаарын хөлгийг бүртгэх, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, гадаадын иргэн гэрээгээр үүрэг гүйцэтгэх болон улсын нисэхийн аюулгүй байдал, нислэгийн үйл ажиллагааны хяналт, зохицуулалтын талаарх эрх зүйн зохицуулалтыг өөрчлөх, боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Түүнчлэн улсын нисэхийн асуудлыг удирдан чиглүүлэх асуудлын хүрээнд Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрх болон Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага, улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагуудын чиг үүргийг нарийвчлан тодорхойлсноороо онцлог бөгөөд тус хууль батлагдсанаар улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын нислэгийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчин сайжирч, улсын нисэхийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, аж ахуйн нэгж, төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын хүлээх үүрэг, хариуцлага, хяналт, зохицуулалт тодорхой болж, түүнийг дагалдан хуулийг хэрэгжүүлэх бусад эрх зүйн баримт бичгүүд боловсронгуй болох, хуулийн давхардал, хийдэл, зөрчил арилах зэрэг чухал ач холбогдолтой байна.

1.2 Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Тус хуулийн нэмэлт өөрчлөлтөөр зөвшөөрөл олголтын процессыг хөнгөвчлөх хүрээнд олон улсын байгууллагаас хийсэн судалгааны тайлан,

гадаадын зарим улсын зөвшөөрлийн харилцааг зохицуулж буй хууль, эрх зүйн зохицуулалт, туршлагыг судалж, олон улсад хэрэглэгдэж байгаа мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг бий болгож, зарим төрлийн тусгай болон энгийн зөвшөөрлийг мэдэгдэл хүргүүлсний үндсэн дээр эрхлэх, тусгай зөвшөөрлийн төрөл ангиллыг дахин тодорхойлох, нэр томъёог жигдлэн хуульчлах, тодорхой төрлийн зөвшөөрөл олгох процессын журмыг салбарын хуулиудад тусгаж оруулах, зөвшөөрөл эзэмшигчид тавих явцын хяналтыг сайжруулах зохицуулалтуудыг тусгасан байна.

Зөвшөөрлийн эрсдэлийн түвшин багатай үйл ажиллагаа, эсхүл нэг удаагийн шинжтэй, тодорхой хугацаанд эрхлэх, ахуйн хэрэгцээний зориулалтаар эрхлэх үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаанд хамааруулахаар заасан ба хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт Мэдэгдлийн жагсаалтыг баталсан байна.

1.3 Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

УИХ-ын 2026 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан ба тус нэмэлт, өөрчлөлтийн онцлох зохицуулалтуудыг танилцуулж байна. Үүнд:

1.3.1 Хөрөнгө оруулалтын зарчим

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зарчмаас гадна хөрөнгө оруулагчид шударга, тэгш хандах, хөрөнгө оруулагчийг үл ялгаварлан гадуурхах, хөрөнгө оруулалтыг хамгаалах, хөрөнгө оруулалтын үр шим, хууль ёсоор олсон орлого, хөрөнгөө чөлөөтэй эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хөрөнгө оруулалтын орчны ил тод, тогтвортой, урьдчилан таамаглахуйц байдлыг хангах, гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх, тогтвортой, хариуцлагатай хөрөнгө оруулалтыг дэмжих зарчмыг баримтална.

1.3.2 Хөрөнгө оруулалтын хэлбэр

Тус хуулийн 5 дугаар зүйлд зохицуулсан хөрөнгө оруулалтын хэлбэрт үйлдвэр, машин механизм, технологи дамжуулах, барилга байгууламжийн үндсэн хөрөнгөд биет байдлаар хөрөнгө оруулалт хийх болон оюуны өмчийн эрхийг холбогдох хуульд заасны дагуу эдийн засгийн эргэлтэд оруулахад хөрөнгө оруулалт хийх хэлбэрийг шинээр оруулж, хөрөнгө оруулалтын хэлбэрийг нэмэгдүүлсэн байна.

1.3.3 Хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэх

Хөрөнгө оруулагч нь төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн талаарх гомдлыг хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гаргахаар зохицуулсан ба Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хөрөнгө оруулагчийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журмыг тогтоосон байна.

1.3.4 Тогтворжуулах гэрчилгээ олгох хугацаа

Хөрөнгө оруулагчид Тогтворжуулах гэрчилгээ олгох замаар хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийн төлөх татварын хувь, хэмжээг гэрчилгээний хүчинтэй байх хугацаанд

Тогтворжуулах зорилготой бөгөөд энэхүү нэмэлт өөрчлөлтөөр Монгол Улсын нутаг дэвсгэрт таваас доошгүй жилийн хугацаанд төсөл хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын хэмжээ, нутаг дэвсгэрээс хамаарч тогтворжуулах гэрчилгээний хугацааг 10-20 жил байхаар нэмэгдүүлсэн байна. Гэхдээ, Тус нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөөс өмнө тогтворжуулах гэрчилгээ авсан хуулийн этгээдийн тогтворжуулах гэрчилгээний хугацаа, нөхцөл нь уг гэрчилгээний хугацаа дуусах хүртэл хүчинтэй байна.

II. УЛСЫН ИХ ХУРАЛ: ОНЦЛОХ ТОГТООЛ

2.1 Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Тус тогтоолоор хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, дэмжих чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасан. Үүнд:

- ✓ Хүүхэд хамгааллын тогтолцооны талаар анхаарах зарим асуудлаар;

- ✓ Иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхийн хэрэгжилтийн талаар;
- ✓ Шүүх шинжилгээ ба хүний эрхийн талаар;
- ✓ Олон нийтийн мэдэх эрхийн төлөв байдлын талаар;
- ✓ Хүний эрх хамгаалагчийн эрхийн хэрэгжилтийн талаар;
- ✓ Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад эрэгтэйчүүдэд тулгамдаж байгаа асуудлын талаар арга хэмжээ авахыг тус тус даалгасан байна.

III. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

3.1 Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам

Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 278 дугаар тогтоолоор Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.10 дахь хэсгийг тус тус үндэслэн "Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам"-ыг баталсан байна.

Энэхүү журмаар банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үйл ажиллагаанд баримтлах үзүүлэлт, түүнд тавих хяналт болон дэвшилтэт технологи ашиглан цахим (цаашид "финтек" гэх)-аар зээлийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар заасан байна. Банк бус санхүүгийн байгууллагаас олгох хэрэглээний зээл нь дараах өр, орлогын болон зээл, үнэлгээний харьцааг хангасан байна. Үүнд:

- ✓ хэрэглээний зээлийн бүтээгдэхүүнд тооцох өр, орлогын харьцаа 55 хувиас хэтрэхгүй;
- ✓ суудлын автомашин барьцаалсан болон худалдан авах хэрэглээний зээлийн зээл, үнэлгээний харьцаа 60 хувиас хэтрэхгүй ба үнэлгээг тооцохдоо автомашин худалдах, худалдан авах гэрээний үнэ эсхүл зах зээлийн үнийг үндэслэнэ.

Мөн Финтек зээлийн үйлчилгээ гаргахад тавигдах шаардлага, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, Финтек зээлийг олгох үйл ажиллагаанд баримтлах журмыг нарийвчлан тусгасан байна.

ALISON & KATE PARTNERS

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Олимпийн гудамж, Centrum Office, 3
давхар, 301/a
Web: www.akp.mn
E-mail: contact@akp.mn
Tel: 7704-1414, 8013-0414